



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 8/124

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монголын Улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, 10.1, Засгийн газрын 2016 оны "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 234 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 08 дугаар сарын 29-ний "Хөтөлбөр батлах тухай" 56 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 03/03 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.5.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүмүүнлэгийн чиглэлээрх төрийн зарим чиг үүргийг аймгийн Улаан загалмайн хороогоор гүйцэтгүүлэхэд 15,000,000 (арван таван сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Аймгийн Улаан загалмайн хорооны 2022 оны үйл ажиллагааны тайланг дүгнэн, 2023 онд хамтран ажиллах гэрээг байгуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-д үүрэг болгосугай.

3.Дээрх 15,000,000 (арван таван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0318

D:My Doc. Zahiramj. Zasag darga